



**МОНГОЛ УЛСЫН
ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ**

Засгийн газрын XI байр, Самбуугийн гудамж 11,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 33 33,
Цахим шуудан: info@med.gov.mn

2024. 06. 27 № 03/1262
танай _____-ны № _____-т

Тайлан хүргүүлэх тухай

Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавар, Ерөнхий сайдын захирамж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийн 2024 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.3-т заасны дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн танилцуулга, холбогдох тайланг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: ... хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

И.БАТХҮҮ

Сайхантамир Пүрэвээ

From: Төгөлдөр Баттулга
Sent: Friday, June 21, 2024 5:20 PM
To: Сайхантамир Пүрэвээ
Сс: Төгөлдөр Баттулга
Subject: Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт - Тайлан хүргүүлэх тухай
Attachments: Төгөлдөр Баттулга-2024-06-21T09_17_04.8467293Z_Батхүү Идэш.pdf

Importance: Low

Албан бичгийн төслийн хяналтын карт

Төслийн холбоос:

https://medgov.sharepoint.com/:w:/s/MED/docs/EddpWlrBvX1Ik646mhttX_0Bl9SUdNtUKP2hxxdm8cGKhQ

Хаана, хэнд: Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт

Товч агуулга: Тайлан хүргүүлэх тухай

Яамны удирдлагаас өгсөн заалт: -

Баталгаажуулсан албан тушаалтнууд:

Очирваань Дэмбэрэл 6/21/2024 4:56 PM

Одончимэг Отгон 6/21/2024 5:08 PM

Батхүү Идэш 6/21/2024 5:16 PM

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАНГИЙН ТАНИЛЦУУЛГА

Нэг. Зорилго

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Эдийн засаг, хөгжлийн яамны хэрэгжүүлэхээр хяналтад авсан Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавар, Ерөнхий сайдын захирамж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийн 2024 оны эхний хагас жилийн хэрэгжилт болон үр дүнг тодорхойлж, хэрэгжилтийг сайжруулахад шаардлагатай дүгнэлт, зөвлөмж боловсруулах, тайланг нэгтгэн хэлэлцүүлэх, удирдлагыг мэдээллээр хангахад оршино.

Хоёр. Арга зүй

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралт “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3 дахь заалтыг баримтлан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийг үнэлэх аргачлалаар хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж гүйцэтгэсэн.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд 2024 оны эхний хагас жилийн байдлаар:

- Монгол Улсын хууль 10 шийдвэрийн 22 заалт;
- Улсын Их Хурлын тогтоол 25 шийдвэрийн 64 заалт;
- Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол 11 шийдвэрийн 34 заалт;
- Ерөнхийлөгчийн зарлигийн 3 шийдвэрийн 6 заалт;
- Засгийн газрын тогтоол 37 шийдвэрийн 62 заалт;
- Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 65 шийдвэрийн 143 заалт;
- Засгийн газрын албан даалгавар 3 шийдвэрийн 8 заалт;
- Ерөнхий сайдын захирамж 8 шийдвэрийн 8 заалт;
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж 1 шийдвэрийн 2 заалт.

Нийт 163 шийдвэрийн 349 заалтын хэрэгжилтийг тайлагнахаар Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд оруулсан.

Эдийн засаг, хөгжлийн яамнаас бүрэн хэрэгжүүлсэн болон Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудалд хамааралгүй буюу 100 хувийн хэрэгжилттэй 66 заалтыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сангийн хяналтаас хасуулахаар тусгалаа.

Хүснэгт 1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр

дд	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр	Шийдвэрийн тоо	Заалтын тоо	Хугацаа болоогүй	Хяналтаас хасуулах саналтай
1	Монгол Улсын хууль	10	22	1	7
2	Улсын Их Хурлын тогтоол	25	64	2	12
3	УИХ-ын байнгын хорооны тогтоол	11	34	1	18
4	Ерөнхийлөгчийн зарлиг	3	6	-	-
5	Засгийн газрын тогтоол	37	62	4	9
6	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	65	143	10	20
7	Засгийн газрын албан даалгавар	3	8	1	-
8	Ерөнхий сайдын захирамж	8	8	-	-
9	ҮАБЗ-ийн зөвлөмж	1	2	-	-
Нийт		163	349	19	66

Дээрх хүснэгтээс үзэхэд хэрэгжилтийг тайлагнах хугацаа болоогүй 19 заалт, хяналтаас хасуулах саналтай 66 заалт байх бөгөөд нийт 264 заалтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн:

1. Монгол Улсын хуулийн 22 заалтаас 100 хувийн хэрэгжилттэй 21 заалт, дунджаар 100.0 хувийн үнэлгээтэй.
2. Улсын Их Хурлын тогтоолын 64 заалтаас 100 хувийн хэрэгжилттэй 60 заалт, 70 хувийн хэрэгжилттэй 2 заалт, дунджаар 99.0 хувийн үнэлгээтэй;
3. Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоолын 34 заалтаас 100 хувийн хэрэгжилттэй 33 заалт, дунджаар 100.0 хувийн үнэлгээтэй;
4. Ерөнхийлөгчийн зарлигийн 6 заалтаас 100 хувийн хэрэгжилттэй 4 заалт, 70 хувийн хэрэгжилттэй 2 заалт, дунджаар 90.0 хувийн үнэлгээтэй;
5. Засгийн газрын тогтоолын 62 заалтаас 100 хувийн хэрэгжилттэй 57 заалт, 70 хувийн хэрэгжилттэй 1 заалт, дунджаар 99.4 хувийн үнэлгээтэй;
6. Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн 143 заалтаас 100 хувийн хэрэгжилттэй 131 заалт, 70 хувийн хэрэгжилттэй 2 заалт, дунджаар 99.5 хувийн үнэлгээтэй;
7. Засгийн газрын албан даалгавар 8 заалтаас 100 хувийн хэрэгжилттэй 7 заалт, дунджаар 95.7 хувийн үнэлгээтэй;
8. Ерөнхий сайдын захирамжийн 8 заалтаас, 100 хувийн хэрэгжилттэй 7 заалт, 70 хувийн хэрэгжилттэй 1 заалт, дунджаар 96.2 хувийн үнэлгээтэй;
9. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийн 2 заалтаас 100 хувийн хэрэгжилттэй 2 заалт, дунджаар 100.0 хувийн үнэлгээтэй байна.

Монгол Улсын хуулийн 1 заалт, Улсын Их Хурлын тогтоолын 2 заалт, Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоолын 1 заалт, Засгийн газрын тогтоолын 4 заалт, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн 10 заалт, Засгийн газрын албан даалгаврын 1 заалт, тайлагнах хугацаа болоогүй нийт 19 заалтын үнэлгээг тооцож оруулаагүй болно.

Дөрөв. Дүгнэлт

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хийгдсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр 322 заалт бүрэн хэрэгжсэн буюу 100 хувийн хэрэгжилттэй,

хэрэгжих шатандаа байгаа буюу 70 хувийн хэрэгжилттэй 8 заалт, хяналтаас хасуулах саналтай заалт 66, хугацаа болоогүй 19, нийт үнэлэгдсэн 264 заалтын хэрэгжилт дунджаар 99.2 хувьтай байна.

Хүснэгт 2. Хяналт, шинжилгээ, үнэлгээний дүн

ДД	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр	Шийдвэрийн тоо	Заалтын тоо	Хэрэгжилтийн хувь				Дундаж үнэлгээ, %
				100	70	30	0	
1	Монгол Улсын хууль	10	22	21	-	-	-	100.0
2	Улсын Их Хурлын тогтоол	25	64	60	2	-	-	99.0
3	УИХ-ын байнгын хорооны тогтоол	11	34	33	-	-	-	100.0
4	Ерөнхийлөгчийн зарлиг	3	6	4	2	-	-	90.0
5	Засгийн газрын тогтоол	37	62	57	1	-	-	99.4
6	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	65	143	131	2	-	-	99.5
7	Засгийн газрын албан даалгавар	3	8	7	-	-	-	100.0
8	Ерөнхий сайдын захирамж	8	8	7	1	-	-	96.2
9	ҮАБЗ-ийн зөвлөмж	1	2	2	-	-	-	100.0
Нийт		163	349	322	8	-	-	99.2

Тав. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 10.4-т “Хэрэгжилтийн тайланг цахим санд оруулахдаа тухайн зорилт, арга хэмжээ, заалтын хүрсэн үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтаах бөгөөд шаардлагатай бол нотлох баримтыг файлаар хавсаргаж болно.” гэж заасны дагуу тайланг 2000 тэмдэгтэд багтаан ирүүлэх;
2. Газрын хурлаар арга хэмжээ тус бүрийн гүйцэтгэлийг хэлэлцэж тайлан, мэдээллийг нэгтгэж албажуулж ирүүлэх;
3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн “70” хувийн хэрэгжилттэй арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх;
4. Зорилт, арга хэмжээний хүрсэн түвшин, үр дүнг тайлагнахдаа зорилтот түвшинд хүрсэн эсэх болон шийдвэрлэгдсэн гол ажлыг оновчтой, товч тодорхой байдлаар бичих.

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ